

Монголын Зүүн-Өмнөд нутгийн Дэд бүтэц, Хүрээлэн байгаа орчин ба Бүс нутгийн хөгжил

Асуудлуудын тэмдэглэл

Өмнөд Говийн бүс нутаг нь дэлхий нийтийн анхаарал татахуйц ач холбогдолтой олборлох уурхайнуудыг байгуулж хөгжүүлэх төлөвлөгөөндөө суурилан эдийн засгийн идэвхтэй үйл ажиллагаанд хамрагдахад бэлэн болж байна. Парламент (Улсын Их Хурал) нь Айвенхоу Майнс компанитай байгуулахыг санал болгосон Оюу Толгойн зэс, алт олборлох уурхай байгуулах Хөрөнгө оруулалтын Гэрээ болон Таван Толгойн нүүрсний уурхай байгуулах саналтай холбогдсон хувь нийлүүлэгчдийн гэрээг тус тус хэлэлцэж байгаа юм. Ойрын ирээдүйд хөгжүүлж болох бусад уурхайн хувьд Цагаан Суваргын (ЦС) зэс, молибдений болон Нарийн Сухайтын экспортын нүүрсний уурхайнуудыг оруулж байна. Энэ бүс нутагт дэд бүтцийг хөгжүүлэх нь бусад уул уурхай болон түүнтэй холбоотой үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд түлхэц болох магадлалтай юм.

2007 оны 10 дугаар сард ажилласан Дэлхийн Банкны ажлын хэсэг нь гол гол дэд бүтэц, хүрээлэн байгаа орчин болон бүс нутгийн хөгжлийн дараах асуудлуудыг тодорхойлж авч үзсэн болно.

Усны нөөц

Өмнө Говийн бүс нутаг дахь усны эх үүсвэрийн асуудал нь тус бүс нутгийг хөгжүүлэх боломжийг хязгаарлаж болзошгүй юм. 1980-аад оноос хойших хугацаанд энэ хавийн нутагт усны нөөцийг нэмэгдүүлэх чиглэлээр хэд хэдэн судалгаа хийгдсэн хэдий ч төдийлэн сайн үр дүнд хүрээгүй байна.

Айвенхоу компани Оюу Толгой төвтэй 100 км-ийн радиус нутагт усны хайгуулын судалгаа явуулсан бөгөөд уурхайн хэрэгцээг хангахад хангалттай хэмжээний усны нөөц бүхий газрын гүний усны 3 эх үүсвэрийг илрүүлсэн юм. Уурхайн олборлолтын хэмжээ өсөхийн хамт усны хэрэгцээ нь өдөрт 37 сая литрээс 60 сая литрийн хооронд хэлбэлзэж байхаар Авенхоу компанийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тооцсон байна. Эхний 25-30 жилд Гүний хоолойн хагалбарын/усан сангийн усыг ашиглах ба харин түүний нөөц дуусах үед Галбын говийн усан сангийн усыг ашиглахаар төлөвлөсөн байна. Эдгээр бассейны ус нь ундны зориулалтаар хэрэглэх боломжгүй, мөн одоо мэдэгдэж байгаагаар хоорондоо алслагдсан, ойр хавьд нь өөр усан сангийн болоод гадаргуугийн усны эх үүсвэр байхгүй болохыг Авенхоу компанитай хийсэн уулзалт дээр компанийнхан дурьдаж байсан. Төлөвлөж буй ус ашиглалтын байгаль орчин дахь нөлөөллийн үнэлгээг Байгаль орчны яам баталсан байна. Үүнээс үзэхэд Оюу Толгойг хөгжүүлэхэд шаардлагатай боломжийн усны нөөц байгаа болохыг харуулж байна.

Гэтэл Оюу Толгойгоос гадна бүсийн хэмжээнд дараахь усны эрэлт хэрэгцээний эх үүсвэрүүд байна:

- Нүүрс угаах үйлдвэр - Таван Толгойн нүүрсний ордоос жилд 50 сая тонн ба түүнээс их олборлолт хийхэд (үүний 25 сая тонн коксжих нүүрснийг экспортоор гаргах ба дотоодын хэрэгцээнд мөн 25 сая эрчим хүчний нүүрс) усны нэг өдрийн хэрэгцээ нь 65 сая литр байна.
- Эрчим хүчний үйлдвэр – 400МВольтын цахилгаан станцд өдөрт 30 сая литр эргэлтийн ус шаардлагатай болно. Улсын хойд хэсгийг болон Хятад улс руу эрчим хүчний шугам татах шийдвэр гарлаа гэхэд энэ бүсэд томоохон хүчин чадлын эрчим хүчний станц байгуулах шаардлага гарах юм. Ус хэрэглэдэггүй технологийн хувилбар байдаг ч ийм эрчим хүчний үйлдвэрийг барих болон ашиглалтанд оруулах нь илүү их өндөр өртөгтэй.
- 10000 оршин суугчтай хот суурингийн өдрийн хэрэгцээнд 2.5-4 сая.литр ус хэрэглэнэ (Монгол улсын өнөөгийн усны хэрэглээнд үндэслэсэн тооцсон байна).
- Үүний зэрэгцээ бусад аж үйлдвэрүүдийн хэрэгцээнд ус шаардагдана.

Дээрхи усны эрэлт хэрэгцээний эх үүсвэрүүдийг хангахуйц усны нөөц Өмнөд говийн бүсэд байгаа эсэх нь тодорхойгүй байна. Уурхайг усаар хангах үүднээс гүний усны сангуудыг ширгээх нь хүлээн зөвшөөрөгдөх хувилбар болох байсан ч (байгаль орчны шинжилгээ хийх нэг асуудал), уурхайгаас гадна бусад аж үйлдвэрүүдийг нөхөн сэргээгдэх усны эх үүсвэрээс хангах нь илүү зохимжтой байх бөгөөд уурхай ашиглалтын жилээс хамаарахгүй цаашид ч хэвээр усаар хангагдах боломжтой юм. Үүний боломжийн тогтвортой нэг хувилбар бол нутгийн хойд хэсгээр урсах голоос 400-500 км усны хоолой татах ажил юм. Энэ хувилбарын өртөг зардал (бараг 1 тэрбум ам.доллар), байгаль орчинд болон нийгэмд үзүүлэх үр дагаврыг тооцож үзээгүй байна.

Тухайн бүсэд ямар ч зүйл хөгжүүлэхийн тул усны нөөцийн талаар нэмэлт судалгаа шаардагдах ба ус ашиглалтаас байгаль орчинд үзүүлэх үр дагаврыг шинжлэн судлах хэрэгтэй. Хамгийн багаар бодоход Оюу толгойн олборлолт эхэлсэнээс хойш буюу гурав дахь жилээс тус уурхайд ойр байрладаг Ханбогд сумын хүн ам 1600-аас 4000-9000 хүртэл нэмэгдэх ба одоо уг сумын хэрэгцээг хангаж байгаа усны эх үүсвэр тэдгээр хүмүүсийн хэрэгцээг хангахад хүрэлцэхгүй болно. Авенхоу компаний тооцож байгаагаар Ханбогд суманд усны шинэ эх үүсвэр бий болгоход нэмэлт өрөмдлөгийг 3 сая америк доллар зарцуулж, 9 сарын хугацаанд хийх шаардлагатай байна.

Одоо мэдэгдэж байгаагаар нэгээс хоёр томоохон уурхайн төсөл тухайн бүсэд хэрэгжих нь гарцаагүй байгаа ба үүнээс үүдэж оршин суугчдийн тоо мэдээж өсөх юм. Бүсийн хөгжлийн саад болох суурь нөхцлүүдийг тодорхойлохын тулд тус бүсийн хэмжээнд усны нөөцийн судалгааг явуулах нь зүйтэй байна. Усны гол эх үүсвэрүүдийн байршлыг тогтоох, ус ашигласнаар байгаль орчинд тогтвортой, бага нөлөө үзүүлэх эсэх, ус ашиглалтын хязгаарыг ойлгож мэдэхэд энэхүү шинжилгээ судлагаа чиглэгдэнэ.

Цахилгаан эрчим хүч

Оюу Толгойн хөрөнгө оруулалтын гэрээг дүгнэхэд хүндрэлтэй гол асуудлуудын нэг нь цахилгаан эрчим хүчний тухай заалтын хэсэг байсан. Авенхоу компанид олборлолтын эхний жилээс л 130 МВольтын хүчин чадалтай цахилгаан эрчим хүч шаардлагатай.

Төвийн Эрчим хүчний системээс (ТЭХС) Оюу Толгой хүртэл өндөр хүчдэлийн шугам тавихаар Монголын Засгийн газар төлөвлөсөн байсан ба Сангийн яам энэ жилийн төсөвтөө барилгын ажилд шаардлагатай хөрөнгийг тусгасан байна. ТЭХС нь нөөцийн доод хязгаарын 10 орчим хувийн хүчин чадлаар ажиллаж байгаа бөгөөд жилээс жилд эрэлт хэрэгцээ нь 7-10 хувиар өсөж байдгийг энд тэмдэглэх нь зүйтэй юм. Одоогоор ажиллаж байгаа цахилгаан үүсгэвэр гаргадаг үйдвэрүүд нь хуучирч, ашиглалтын хугацаа нь дуусч байна. Хэрэгцээнд хэт ачаалал гарах үед Орос улсаас цахилгаанаар хангах боломжтой боловч ТЭХС-ийн хүчин чадлыг нэмэгдүүлэх шаардлагатай байгаа нь илэрхий байна. Цахилгааны хэрэгцээ өсч байгаа хэдий ч хуучин эрчим хүчний үйлдвэрүүдийн технологийг шинэчлэн солих, мөн орчин үеийн технологитой үйлдвэрийг шинээр барьж байгуулах нь Улаанбаатарын хотын агаарын бохирдлыг бууруулахад нөлөөлөх юм.

Өндөр хүчдэлийн шугам байгуулах шийдвэр гарсан бололтой. Мөн Хятад улсаас эрчим хүч импортловол өндөр хүчдэлийн шугамын урт багасаж өртөг нь арай бага тусах хувилбар байж болох юм. ТЭХС-ээс худалдах цахилгааны үнийг санхүүгийн шинжилгээгээр судлах нь зүйтэй ба хамгийн сүүлийн Дэд бүтцийн бодлогын дагуу эрчим хүчний үнэ бүтээгдэхүүний үнээс бага байгааг харуулж байна. Төлөвлөж буй өндөр хүчдэлийн шугамын техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулахад хэдэн жилийн дараа Өмнөговь аймгаас Улаанбаатарт цахилгаан нийлүүлнэ гэдгийг харгалзан түүний хүчин чадлын асуудлыг авч үзэх хэрэгтэй.

Дунд хугацаанд, нүүрсээр ажилдаг цахилгаан станцуудыг Таван Толгойд буюу Өмнөговийн аль ч хэсэгт барьж болох юм. Таван Толгойг хөгжүүлэх төлөвлөгөөг боловсруулах явцад Таван Толгойн хөрөнгө

оруулалтын гэрээнд эрчим хүчний үйлдвэрийг уурхайн олборлолт хариуцагч, эсвэл бие даасан гэрээлэгч, эсвэл Засгийн газраас барьж байгуулах тухай заалтыг оруулах эсэхийг Засгийн газар авч үзэх болно. Салхины эх үүсвэрээр цахилгаан гаргаж авдаг жижиг үйлдвэрлэгчтэй Засгийн Газраас анхны хувийн эрчим хүч худалдан авах гэрээ байгуулсан хэдий ч хувийн хөрөнгөөр цахилгаан үйлдвэрлэх хувилбаруудыг ойлгохын тулд хувийн хөрөнгө оруулалт хийх эрх зүйн орчинг бэлтгэх, барилга ажлын нөхцөл болон эрчим хүчний үйл ажиллагааг зохицуулах талаар хэлэлцэн тохирох зэрэгт ихээхэн хэмжээний техникийн туслалцаа шаардлагатай болох юм.

Таван Толгойд байгуулах үйлдвэрийн хүчин чадлаас хамааран Хятад улс руу эрчим хүч экспорлож болох юм. Эрчим хүч оруулах Хятадын шаардлагад нийцүүлэхийн тулд өндөр хүчин чадалтай үйлдвэрээс дамжуулах 550 КВатын өндөр хүчдэлийн шугам барьж байгуулах шаардлага гарч болзошгүй. Эрчим хүчний экспортын талаар төлөвлөгөө гаргахад техникийн туслалцаа өгч болох юм.

Тээвэр

Зам тээвэр, аялал жуулчлалын яамнаас Улаанбаатараас Өмнөговь аймгийн төв Даланзадгад хүртэл 520 км зам тавих төлөвлөгөө гаргасан байна. Түүний техник-эдийн засгийн үндэслэл боловсруулах ажил эхлээд байна.


ВОТ-ийг Нарийн Сухайтын уурхайн хажуугаар гардаг Хятадын хилтэй ойрхон гардаг замтай холбох ажил эхлээд байна. Замын барилгын ажлыг Хятадын компани хариуцаж байгаа бөгөөд Зам тээвэр, аялал жуулчлалын яам барилгын ажлын зардлыг 200,000-250,000 төг/км гэж тооцжээ.

Оюу Толгойн тээврийн хэрэгцээнд Хятад улсын хил хүртэл 150 км ВОТ зам байхад хангалттай юм. Замын санхүүжилт болон барилгын ажлыг Айвенхоу компани хариуцах ба замын засвар үйлчилгээ болон төлбөртэй замын ашиглалтыг Зам тээвэр, аялал жуулчлалын яам хариуцахаар тогтосон гэж ойлгож байна (Айвенхоу компани зам ашигласны төлбөрөөс чөлөөлөгдөнө). Айвенхоу компани замын барилгын ажлын тендерийг хэдийн зарлаад байгаа ба энэ ажлын байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг Байгаль орчны яамаар батлуулсан бөгөөд Хөрөнгө оруулалтын гэрээнд гарын үсэг зурагдвал барилгын ажлыг эхлүүлэхэд бэлэн болгоод байна.

Таван Толгойн уурхайн ашиглалт эхэлмэгц төмөр зам барих шаардлагатай болно. Учир нь их хэмжээний нүүрсийг тээвэрлэх цорын ганц бодит хувилбар бол төмөр зам юм. Замт тээвэр, аялал жуулчлалын яамны боловсруулсан төмөр замын төсөл нь Зураг 1-т үзүүлсэн шугамын дагуу баригдах ба энэ нь Оюу Толгойн ордоос Хятадын хил хүртэл 80 тууш км мөн

Транс-Монголын төмөр зам хүртэл ойролцоогоор 400 км төмөр зам тавих юм. Зам тээвэр, аялал жуулчлалын яам нь Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд энэхүү төлөвлөж байгаа замын төслийг хүргүүлээд байгаа ба эдгээр төслийг батлагдвал техник-эдийн засгийн үндэслэлийг эхлүүлэх юм байна.

Зураг 1. Өмнөд говийн бүсэд төлөвлөж буй төмөр замын сүлжээ



Газрын зургыг: Айвенхой майнс вэб хуудас (2007)

Өнөөгийн төмөр замын сүлжээг өргөтгөхөөс гарах үр дагаврыг тооцох эдийн засгийн шинжилгээ судалгаа хийх хэрэгтэй. Засгийн газрыг төлөөлж төрийн өмчийн “Эрдэнэс” компани нь төмөр замын талаар гарч байгаа олон хувилбаруудын үнийн судалгааг гаргах, мөн Орос болон Хятад улс руу эрдэс баялаг тээвэрлэх зардлыг тогтоох ажил орж байна. Гэхдээ энэхүү судалгаа нь одоогоор эхний үе шатандаа явж байгаа ба энэ талаар Зам тээврийн яаманд мэдэгдээгүй бололтой байна. Төмөр замын сүлжээг хэсэгчилэн барьсанаар хөрөнгө оруулалтын өгөөжийн хувь хэмжээг нэмэгдүүлэх юм.

Төмөр замын сүлжээг хөгжүүлсэнээр бүсийн хэмжээнд уул уурхай болон бусад аж үйлдвэрийг цаашид хөгжүүлэх хөшүүрэг болох боломжийг эдийн засгийн үнэлгээнд тооцох хэрэгтэй. Авенхоу компаний тооцоолсоноор

Хятадын металлургийн үйлдвэрүүд рүү хүдрийг автомашинаар зөөх зардал ойролцоогоор 38 ам.доллар/тонн болох бол төмөр замаар тээвэрлэхэд энэ нь ойролцоогоор 20 ам.доллар/тонн байх ба Таван Толгойн ойр төмөр зам байгуулбал Авенхоу компани нь энэ төмөр замаар үйлчлүүлэх нь дамжиггүй. Нэгэнт төмөр зам барих юм бол уул уурхайн чиглэлээр ажиллаж байгаа бусад компаниуд төмөр замын сүлжээнд нэгдэх нэмэлт шугам барьж байгуулах нь ашигтай болох юм.

Төмөр замын дугуйны хоорондох зайны талаар Үндэсний аюулгүй байдлын зөвлөл мөн авч үзсэн байдаг. Өмнөговийн эрдэс баялаг болон тэдгээрийн бүтээгдэхүүн гаргах гол зах зээл бол Хятад улс байх ба энэ улс стандартын нарийн төмөр зам ашигладаг. Харин Монгол улсад ашигладаг дугуйны хоорондох зай арай өргөн буюу Оросын өргөн замыг ашигладаг. Төмөр замын дугуй солих явдал тээврийн зардлыг нэмэгдүүлж, замд саатах байдалд хүргэдэг. Иймд Хятад улс руу зорчих төмөр замыг нарийн замтайгаар барьж харин Таван Толгойг улсын гол төмөр замтай холбох хэсэгт Оросын өргөн замыг барих боломжтой юм. Таван Толгойгоос Хятад улсын хил рүү зорчих төмөр замын талаар шийдвэр гаргах үед дугуй солихтой холбоотой гарах зардлыг үнэлгээнд мөн авч үзээд энэ талаар мэдээлэл хийх шаардлагатай.

Шинэ төмөр замыг барих, ашиглалтыг хариуцах талаар одоогоор улсын, хувийн гэх зэрэг олон хувилбарууд байдаг. Барилгын ажлын зардал нь километр тутамд 1 сая ам.долларт хүрч магадгүй байна. Монголын төмөр замыг Орос-Монголын хамтарсан хувьцаат компани эзэмшдэг бөгөөд Оросын хувьцаа эзэмшигчид цаашид төмөр замын сүлжээг өргөтгөхөд хөрөнгө оруулалт хийх хүсэл сонирхолгүй байна. Иймд Зам тээвэр, аялал жуулчлалын яам хувийн хөрөнгө оруулалтыг дэмжихэд бэлэн байгаа ба төмөр зам барих хэд хэдэн албан бус санал хүлээн аваад байна. Төмөр замын тээврийн шинэ хуулиар замын дэд бүтцийн 51 хувийг заавал төр эзэмшинэ гэсэн заалт байдаг байна.

Таван Толгойг хөгжүүлэх төлөвлөгөө боловсруулах явцад Таван Толгойн хөрөнгө оруулалтын гэрээнд төмөр замын барилгын ажлыг олборлолт явуулж байгаа компани, эсвэл бие даасан гэрээлэгч, эсвэл Засгийн газар барих тухай заалтыг оруулах эсэхийг Засгийн газар авч хэлэлцэх болно.

Цэвэр уурхайн зориулалтаар олборлолт явуулж байгаа компани төмөр замын ашиглалтыг хариуцаж байгаа тохиолдолд л төмөр замын бүтээмж хамгийн өндөр байдаг гэдгийг олон улсын туршлага харуулдаг. Олборлолт явуулж байгаа компани нь төмөр замын ашиглалтыг хариуцаж байхад өөр бусад компаниуд энэ төмөр замыг ашиглах боломжтой байх уу гэдэгт л асуудал оршиж байна. Иймэрхүү хүндрэлтэй асуудал шинэ биш бөгөөд улс орон өөр өөр арга аргачлалыг өөрийн нөхцөл байдалд тохируулан асуудлыг шийдсэн байдаг. Өмнөговьд төмөр замын ашиглалт,

барилгын ажлыг явуулах олон хувилбаруудыг сайн ойлгох тал дээр Дэлхийн Банк Монголын Засгийн газарт техник туслалцаа үзүүлэх саналтай байна.

Хүрээлэн байгаа орчин

Монголын Говийн бүс нутаг нь өргөн уудам талбайтай, тархуу цөөн хүн амтай, эрдэс түүхий эдийн арвин баялаг нөөцтэй, тээврийн сүлжээний цөөхөн замтай, устаж үгүй болох аюул тулгарсан олон төрлийн амьтан, ургамлын өлгий нутаг бөгөөд бороо хур тунадас болон усны эх үүсвэр багасч буй газар нутаг юм. Мөн түүнчлэн энэ бүс нутагт социализмын захиргаадалтын эдийн засаг нурсаны дараагаар улс төр, эдийн засгийн асар их өөрчлөлт, хүндрэл бэрхшээлүүдийг даван туулсан олон тооны малчид амьдардаг бөгөөд хүн амын өсөлтөд ч тэд хувь нэмрээ оруулж ирсэн. Монгол улс хувийн хэвшлийн эдийн засгийн тогтолцоо руу шилжихийн хамт хүн амын нягтаршил болон олборлолтын эдийн засгийн үйл ажиллагаа, тухайлбал уул уурхай ба түүнтэй холбоотой дэд бүтцийн хөгжил нь цаашид тус бүс нутгийн байгаль орчин болон онгон төрх байдалд нөлөөлж болох талтай байна.

Олон улсын туршлагаас харахад нэр хүнд бүхий стратегийн хөрөнгө оруулагчид хөгжиж байгаа орнуудад томоохон хэмжээний хөрөнгө оруулалт хийхдээ чухал ач холбогдол бүхий дадлага туршлага, олон улсын шилдэг практик, технологи, санхүүжилт болон удирдлага менежментийн арга барилыг оруулж ирдэг. Тухайлбал, уул уурхайн салбарт олон улсын нэр хүнд бүхий компаниуд байгаль орчин болон нийгмийн холбоотой асуудлуудыг өөрсдийн үйл ажиллагаанд харгалзсан стандартыг мөрдөж үйлдвэрлэлээ явуулдаг бөгөөд тухайн орны тавьсан шаардлагын дагуу мэдээллийн ил тод байдлыг хангасан дүрэм журмыг баримталдаг. Монгол улс нь итгэл найдвар бүхий олон улсын компаниудыг ийм стратегийн хөрөнгө оруулагч болгосноор дараах талаар давуу талтай байх болно.

Байгаль орчин болон нийгэмд ээлтэй уул уурхайн салбарыг хөгжүүлсэний давуу талыг нэмэгдүүлэхийн тулд:

- Монголын талын шаардлага ба олон улсын туршлагын дагуу байгаль орчин болон нийгмийн асуудлуудыг төслийн түвшинд гаргаж тавих шаардлагатай (байгаль орчны үнэлгээ болон байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөөг Байгаль орчны ямаар батлуулсан байх);
- Уул уурхайн компаниудын үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх нөлөөлөлд Монголын эрх бүхий байгууллагууд тогтмол мониторинг хийж хяналт тавьж ажиллах шаардлагатай бөгөөд бие даасан зөвлөхүүдийн давуу талыг ашиглах, мэдээллийн ил тод байдлыг хангах асуудлыг анхааралдаа авах нь зүйтэй.

- Уул уурхайг хөгжүүлэх болон бусад төлөвлөгөөтэй холбогдсон байгалийн гол гол нөөцөд цаг хугацааны явцад болон бүс нутгийн хэмжээнд нөлөөлөх хүчин зүйлсийг хамарсан байгаль орчны асуудлуудыг бүс нутгийн түвшинд гаргаж тавих шаардлагатай.

Өнөөгийн байдлаар Байгаль орчны яам (БОЯ), Хүнс, хөдөө аж ахуйн яам болон Газрын харилцааны удирдлагын газраас өөр тус бүс нутагт хөгжүүлэхээр санал болгож буй уул уурхай, дэд бүтцийн үйл ажиллагаанаас гарах үр нөлөөнд хяналт тавих эрх бүхий байгууллага байхгүй байна. Хөдөө орон нутгийн газрын харилцааны удирдлагын асуудалд анхаарал хандуулсан судалгаа Монголд цөөхөн байдаг ба Говийн бүс нутагт анхаарал төвлөрүүлсэн судалгаа байхгүй байна. Говийн бүс нутгийн байгаль орчин ба байгалийн нөөцийн менежментийн мониторингийн судалгааны үзүүлэлтүүд, мэдээллээр хомс, байгаа мэдээлэл нь үнэмшил багатай, олж авах боломжоор хязгаарлагдмал байдаг зэрэг нь Өмнө Говийн бүс нутагт одоо болон ирээдүйд хэрэгжүүлэхээр төлөвлөж буй үйл ажиллагаа нь цаашид байгаль орчны тэнцвэртэй байдлыг алдагдуулахгүй байна гэдгийг батлахад Засгийн газрыг ихээхэн хүндрэлд оруулж байна. БОЯ болон салбар хариуцсан бусад яаманд ойрын болон дунд хугацаанд энэ талаарх мэдээллийн хомсдолыг арилгах төлөвлөгөө байхгүй байна.

Айвенхоу компани нь усны нөөц эх үүсвэр, Оюу Толгойгоос Хятадын хил хүртэлх 100 км зам болон уул уурхайн олборлолтын ажил голлож төвлөрөх хэсгийн хувьд байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн үнэлгээ (БОУ) хийх судалгааны гурван ажлыг хийж гүйцэтгэсэн. Үүнээс эхний хоёр БОУ-ний дүгнэлтийг Байгаль орчны яам хянаж баталсан бол гуравдахь судалгааны дүгнэлтийг тус яам хүлээн авсанаас хойш хоёр жил гаруй хугацаа өнгөрсөн ч үүнийг батлаагүй хэвээр байна. Том хэмжээний олборлох уурхайн үйл ажиллагаатай холбогдсон БОУ-ний дүгнэлт гаргах өөрийн чадавхи хязгаарлагдмал тул тус яам энэхүү судалгааны ажлын дүгнэлтийг гаргахын тулд Дэлхийн Банкнаас тусламж үзүүлэхийг хүсч, яамны нэрийн өмнөөс ажиллах хөндлөнгийн зөвлөхийг авч ажиллуулах боломжтой эсэх тухай асуудлыг тавьсан. Тус Банкнаас үүнтэй холбогдуулан Байгаль орчны Реформыг дэмжих зорилготой Голланд-Монголын Итгэлцлийн Сангийн буцалтгүй техник тусламжийн хөтөлбөрийн хүрээнд ийм тусламж үзүүлж болох талаар зөвлөгөө өгсөн.

Хэрэв Байгаль орчны яам БОУ-ний дүгнэлтийг Оюу Толгойн хөрөнгө оруулалтын гэрээ байгуулагдахаас өмнө батлах боломжгүй байгаа тохиолдолд хөрөнгө оруулалтын гэрээнд дээр дурьдсан дүгнэлтийг тодорхой тогтоосон хугацааны дотор батлуулах болно гэсэн зүйлийг тусгаж болох юм.

Оюу Толгойг ашиглах төсөл батлагдсаны дараагаар БОУ-ний дүгнэлтийн дагуу байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний хэрэгжилтийн явцад мониторинг үнэлгээ хийх шаардлага гарна. Байгаль орчны яам

байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавих ажилд тэргүүлэх чиглэлийг тогтоож техникийн туслалцаа үзүүлэхийг хүссэн. Мөн түүнчлэн Оюу Толгойн төслөөс гадна бусад төлөвлөгөөнүүдэд ч гэсэн бүс нутгийн байгаль орчны үнэлгээ хийх талаар орсон байх шаардлагатай. Дэлхийн Банк эдгээр хэрэгцээ шаардлагыг харгалзан техник туслалцаа үзүүлэхээр төлөвлөж байна.

Бүс нутгийн хөгжил

Бүс нутгийн хэмжээнд нэн даруй шийдвэрлэх шаардлагатай тулгамдсан асуудлуудад цаашид өсөн нэмэгдэх хүн амд зориулсан төв суурин газруудыг бий болгох явдал орж байна. Барилга, хот байгуулалтын яамнаас Оюу Толгой болон Таван Толгой орчмын газар нутгийг хөгжүүлэх газрын харилцааны удирдлагын төлөвлөгөөг саяхан боловсруулж дуусгасан байна. Тус яамны төсөөлж байгаагаар Оюу Толгойн төсөлтэй уялдсан хүн амын тоо өнөөгийн байгаа 5000-аас өсөн нэмэгдэж ойрын хэдэн жилийн дотор 24000 орчим болох юм байна.

Засгийн газар болон Айвенхоу Майнс/Рио Тинто хоёрын хооронд төв суурин газрыг байгуулж хөгжүүлэх асуудлыг орон нутгийн засаг захиргаа удирдаж явуулах шаардлагатай ба уурхайн түр жижиг тосгон байгуулахаас зайлсхийх нь зүйтэй гэсэн тохиролцоонд хүрсэн бололтой. Гэсэн хэдий ч Барилга, хот байгуулалтын яамны хувьд төв суурин газрын дэд бүтцийг байгуулах санхүүжилтийн хөрөнгийн ихэнх хэсгийг уул уурхайн компаниуд гаргана хэмээн үзэж байгаа бололтой байна. Энэ асуудлаар олон улсын туршлага олж судлах болон уул уурхайн төслийг цаашид хэрэгжүүлэхэд баримтлах зарчмыг тогтооход маргаантай хэцүү байх болно.

Монгол Улс нь тус орныг дөрвөн бүс болгон хуваахаас гадна Улаанбаатар хотыг тусад нь авч үзсэн үндэсний хөгжлийн стратегийн төлөвлөгөөтэй байна. Үйлдвэр, худалдааны яам нь хоорондоо уялдаж холбогдсон үйлдвэрлэлийг хөгжүүлэхийг зорьж байна. Өмнө Говийн бүс нутгийн хувьд дээрх төлөвлөгөөнүүд нь зэс, нүүрс, тэмээний ноос, ямааны ноолуур, барилгын материал болон аялал жуулчлалын салбарыг хамаарч байгаа юм. Гэвч тус яам нь эдгээр үйлдвэрлэлийг хэрхэн яаж хөгжүүлэх гэж байгаа нь төдийлөн тодорхой бус байна.

Олон улсын туршлагаас харахад уул уурхайн төслүүд болон бусад үйлдвэрлэлийг хөгжүүлэх төслүүдийн хооронд харилцан бие биендээ нөлөөлөх чиг хандлага ерөнхийдөө маш бага байдаг байна. Иймээс уул уурхайн төсөл нь өөрөө бүс нутгийг өргөн цар хүрээтэйгээр хөгжүүлэх Засгийн газрын төлөвлөгөөг идэвхтэй дэмжиж чадахгүй юм. Гэсэн хэдий ч тус бүс нутагт жижиг, дунд үйлдвэрүүдийг хөгжүүлэх нэлээд нөхцөл бололцоо байгааг хэлэх хэрэгтэй. Дэлхий Банк нь дэд бүтэц, хүний хүчин зүйлийг хөгжүүлэх (тухайлбал, хөдөө орон нутгийн боловсрол) аливаа

хөрөнгө оруулалт болон төсвийн хөрөнгө оруулалтын орчныг сайжруулахад чиглэсэн өөрчлөлтийн реформд илүү анхаарал хандуулсан бүсчилсэн хөгжлийн стратегийг дэмждэг. Бизнесийн үйл ажиллагаанд шууд нөлөөлөхийг оролдсон бодлого нь амжилтанд хүрэх магадлал багатай байдаг бөгөөд зах зээлд нэвтрэх боломж болон агломерацлагдсан эдийн засаг нь бизнест нөлөөлөх голлох хүчин зүйл болж байдаг юм.

Санхүүжилт

Санхүүжилтийн асуудлууд нь улсын төсвийн болон хувийн хэвшлийн санхүүжилтийн аль алиныг хамаарах болно.

Сангийн яам Дунд Хугацааны Төсвийн Хүрээний Зарцуулалтыг (ДХТХЗ) оновчтой болгон хэрэгжүүлж байна. Энэхүү шинжилгээний дээрээс доош нь тооцсон хэсгийн төсвийн хөрөнгөд байгаа бүх багц эх үүсвэрийг дайчилж тооцох ажил хийгдсэн байна. Харин ДХТХЗ-ын дороос дээш тооцсон хэсгийг хэрэгжүүлэхэд илүү бэрхшээлтэй байх бөгөөд энэ нь зарцуулалтын хувилбаруудтай (хөрөнгө оруулалт ба их засвар) дэлгэрэнгүй жагсаалтыг гаргах болон байгаа төсвийн хүрээнд зарцуулалтын төлөвлөгөөг хангах зорилгоор ач холбогдлоор нь системчлэх (эргэн төлөгдөх эдийн засгийн хувь хэмжээ) шаардлагатай байна. ДХТХЗ (MTBF)-ын төслийн бие даасан GAP хэсгийн дагуу Дэлхийн Банкнаас ДХТХЗ-ын нэг хэсэг болсон Улсын Төсвийн Хөрөнгө Оруулалтын Төлөвлөгөө боловсруулах ажил дээр Сангийн яаманд техник туслалцаа үзүүлж байгаа юм. Энэ хэсэг нь Засгийн газрын дэд бүтцийн хөрөнгө оруулалттай холбоотой болно. Үүний гол зорилго нь тус яамны хөрөнгө оруулалтын өнөөгийн урт жагсаалт гаргадаг арга хэлбэрийг өөрчилж Засгийн газрын хөгжлийн стратегитай уялдуулан ач холбогдлоор нь дараалуулан хөрөнгө оруулалт хийдэг хувилбар луу шилжих явдал юм.

Дэд бүтцийн голлох байгууламжуудыг хөгжүүлсэнээр шинэ шинэ уурхайнуудыг хөгжүүлэхэд түлхэц өгөх болно. Эдгээр уурхайн хөрөнгө оруулагчид нь Монголын харьцангуй жижиг компаниуд байж болох бөгөөд тэдний хувьд дэд бүтцийн гол сүлжээнд холбогдсон салаа шугам, замыг байгуулах ажил ашигтай байх боломжтой байна. Хувийн хэвшлийн дэд бүтцийн ийм хөрөнгө оруулалтын харилцан хамааралтай орчин нөхцөл нь дотоодын урт хугацааны хөрөнгийн эх үүсвэрийг бий болгохыг шаардах болно. Засгийн газар нь дэд бүтцийг хөгжүүлэх хөрөнгийн санг байгуулахад ийм санхүүжилтийг гаргах үүргийг хүлээх боломжтой.

Нийгмийн асуудлууд

Өмнөговь, Дорноговь, Дундговь аймгууд нийлээд нийт 150,000 орчим хүн амтай ба 350,000 хавтгай дөрвөлжин километр газар нутагтай (0.43

хүн/км²). Үүнээс 44,000 орчим хүн аймгийн төв болох Даланзадгад, Сайншанд, Мандалговь хотуудад амьдардаг. Хөдөөгийн малчид өнөөгийн нийт хүн амын гуравны нэгийг эзэлж байна.

Уул уурхай байгуулах болон үүнтэй холбоотой дэд бүтцийг хөгжүүлэхэд дараах нийгмийн асуудлууд хөндөгдөх болно. Үүнд:

- өнөөгийн хөдөөгийн хүн ам болон шинээр бий болох уурхай, дэд бүтцийн хөгжлийг дагасан хүн амын хооронд усны нөөц ба бэлчээрийн газар нутгийг эзэмших талаар тэмцэл өрсөлдөөн үүснэ;
- цагаачлан нүүж ирэх ажилчдын олонхи нь Хятадаас ирэх бөгөөд үүнийг нутгийн иргэд хүлээж авах байдал;
- гэрт амьдардаг хүмүүс уурхай дагасан төв суурин газар луу нүүх боломж магадлалтай;
- уурхайн хот суурин газрын нийгмийн бухимдал;
- уурхайн хот суурин газрыг нийгмийн үйлчилгээгээр хангах асуудал;
- барилга байгууламж барих болон уул уурхайн салбарт ажилладаг хүн амын нягтралтай холбогдсон ДОХ/БЗХӨ-ний асуудал;
- бүс нутгийг хөгжүүлэхэд ард иргэдийн оролцоо.